

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН 2012 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН /хураангуй/

Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс Авлигатай тэмцэх газрын 2012 онд дэвшүүлсэн зорилгод тулгуурлан дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

1. Авлигын эсрэг хуульд заасан хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мониторинг, дүн шинжилгээ хийж сайжруулах, хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимтэй явуулах, хяналт шалгалтын ажлын стандартыг боловсруулан батлуулах.

2. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, түүний хяналт, ХОМ-ийн болон өргөдөл, гомдлын хяналт шалгалтын үйл ажиллагааны арга техник, ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, хариуцлагын механизмыг хууль тогтоомжийн боломжийн хүрээнд хэрэгжүүлэх.

3. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтныг сургах, хариуцлагажуулах, чадавхижуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

4. ХОМ-ийн бүрдүүлэлтийг цахимжуулах портал программыг хүлээж авах, ашиглах үйл ажиллагааг бодитой болгох, үүнтэй холбоотой иж бүрэн сургалт, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх.

5. ХОМ-ийн талаарх иргэд, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл авах, өгөх боломжийг бүрэн хангах.

6. Хэлтсийн ажилтнуудын мэргэшил, чадавхийг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Авлигатай тэмцэх газрын 2012 оны төлөвлөгөөний дагуу хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд, мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ, хяналт шалгалтын албадын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг биелүүлж ажилласан бөгөөд тус хэлтсээс хийж гүйцэтгэсэн ажлыг танилцуулж байна.

НЭГ. АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Тус хэлтэс нь Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний алба, хяналт шалгалтын алба гэсэн 2 нэгжтэйгээр шинэчлэн зохион байгуулагдсан. Албад нь хэлтсийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан ажлаа улирал, сараар, ажилтнууд 7 хоногоор төлөвлөн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллаа. Мөн хэлтсийн үйл ажиллагааны нэмэлт төлөвлөгөө, бүрдүүлэлтийн зохион байгуулалтын ажлын төлөвлөгөө, газрын удирдлагаас өгсөн үүргийн дагуу бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх ажлын нэмэлт төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилласан.

ХОЁР. БҮРДҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлын талаар

2.1.1 Авлигатай тэмцэх газарт хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлэх албан тушаалтны нэрсийн жагсаалтыг 2 удаа шинэчлэн гаргаж, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авч бүртгэх хуваарийг хийж, хэлтсийн даргаар батлуулсан.

2.1.2 Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлын тайлангаар тус газарт нийт 270 албан тушаалтан ХОМ-ээ бүртгүүлсэн байна. Тус газарт мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнуудад мэдүүлэг гаргах талаар заавар, зөвлөгөө өгч, эдгээр албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд 100 хувь хүлээн авч бүртгэсэн.

2.1.3 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн ажлын тайлангаар тус газарт мэдүүлгээ бүртгүүлбэл зохих 253 албан тушаалтнаас 252 нь буюу 99.6 хувь нь мэдүүлгээ хуулийн хугацаанд бүртгүүлсэн бөгөөд Эрчим хүчний зохицуулах хорооны орон тооны бус зохицуулагч Д.Жаргалсайхан мэдүүлэг гаргахаас татгалзсан байна.

2.1.4 Тус газарт мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнуудын 2011 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг, шинэчлэн гаргаж өгсөн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг дугтуйлж, хаяглан, “нууц” тэмдэг дарж хадгалсан.

2.1.5 Авлигатай тэмцэх газарт хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлдэг төрийн өндөр албан тушаалтнуудын 2011 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг батлагдсан маягтын дагуу хураангуйлан шивэх, хянах, нэгтгэх ажлыг гүйцэтгэж, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлүүлсэн ба газрын цахим хуудсанд байршуулсан.

2.2.6 Албан тушаалтны 2012 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн шинэчилсэн бүрдүүлэлтийн нэгдсэн дүнгийн тухай танилцуулах тойм мэдээг бэлтгэж, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл, УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд тус тус хүргүүлсэн.

2.1.7 Тус газарт мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнуудын 2011 оны эхний болон шинэчлэн бүртгүүлсэн мэдүүлгийг хариуцсан ажилтан бүрээс хүлээн авсан.

2.1.8 Авлигын эсрэг хууль, албан тушаалтны ХОМ-ийг бүртгэж, хадгалах журмын дагуу 2012 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж, төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагын нийт мэдүүлэг гаргагчдын дүн мэдээ, тайланг хуулийн хугацаанд бүрэн нэгтгэж гаргасан. 2012 оны ХОМ-ийн бүрдүүлэлтээр нийт **58000 орчим** албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлэхээс **99,89** хувь нь бүртгүүлжээ. Мэдүүлэг гаргагчдын 25 нь хожимдуулж бүртгүүлсэн, 64 албан тушаалтан огт бүртгүүлээгүй байна. ХОМ-ээ бүртгүүлээгүй 64 мэдүүлэг гаргагчийн 50 нь буюу 78,1 хувь нь аймаг, сумдын иргэдийн хурлын төлөөлөгч байна.

2.1.9 Мэдүүлгийн эхний бүрдүүлэлтээр хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлээгүй 64, хугацаа хожимдуулж мэдүүлсэн 25 албан тушаалтанд Авлигын эсрэг хуулийн холбогдох заалтыг үндэслэн хариуцлага тооцуулах тухай албан бичгийг төрийн болон нутгийн захиргааны 39 байгууллагын удирдах албан тушаалтанд хүргүүлсэн. Нийт 89 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар албан бичиг хүргүүлснээс хүндэтгэн үзэх шалтгаантай /хүнд өвчний улмаас удаан хугацаанд чөлөөтэй байгаа/ 3, төрийн өмчийн 20-49 хувийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах ажилтан 4, ажлаас чөлөөлөгдсөн, шилжсэн 14 албан тушаалтан, нийт 21 албан тушаалтанд хариуцлага тооцох боломжгүй тухай хариу ирүүлсэн. Хариуцлага тооцох 68 албан тушаалтнаас 66 албан тушаалтанд хариуцлага тооцуулснаас 1 албан тушаалтанд халах, 1 албан тушаалтанд цалинг 3 сарын хугацаанд 20 хувиар бууруулах, 53 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл, 7 албан тушаалтанд анхааруулах, 4 албан тушаалтанд бүрэн эрхийг нь түтгэлзүүлэх арга хэмжээг авсан байна.

2.1.10 Бүрдүүлэлтийн ажлын хүрээнд Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.13 дах заалтыг үндэслэн тус газарт нэгдсэн тайлан, мэдээг

нэгтгүүлдэг төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагуудаас хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг гаргуулан авч хянасан.

2.1.11 Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчдын өөрчлөлт, хөдөлгөөний 2011 оны жилийн эцсийн ХОМ-5 мэдээг төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагуудаас авч нэгтгэсэн. 2011 оны эцэст байгаа хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчийн тоог тухайн байгууллагын ХОМ гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалттай тулгаж хянасан бөгөөд томоохон зөрүү гарсан байгууллагын ЭБАТ-аас зөрүү гарсан шалтгааныг тодруулж, тэдэнд арга зүйн зөвлөгөө өгсөн.

2.1.12 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, төрийн болон нутгийн захиргааны 121 төв байгууллагаас мэдүүлгийн тайлан болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн Сахилгын Хороонд бүртгэж, хүлээн авсан мэдүүлгийн тоог нэгтгэхэд улсын хэмжээнд 2012 оны 8 дугаар сарын 15-ны байдлаар 45000 орчим албан тушаалтан ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахаас 7 нь хугацаа хожимдуулж, 96 албан тушаалтан мэдүүлгээ гаргаж өгөөгүй байна.

Албан тушаалтнуудын 2012 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулж /Хүснэгт-1/ үзүүлбэл:

Хүснэгт 1

Үзүүлэлт		2009 оны ХОМ	2010 оны ХОМ	2011 оны ХОМ	2011 оны ХАСХОМ
Мэдүүлгээ бүртгүүлбэл зохих мэдүүлэг гаргагчийн тоо		54000	56000	58000	45000
Хугацаа хожимдуулж бүртгүүлсэн		15	49	25	7
Огт бүртгүүлээгүй мэдүүлэг гаргагчийн тоо		136	69	64	96
Үүнээс	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч	98	61	50	80
	Бүртгүүлээгүй бусад мэдүүлэг гаргагч	38	8	14	16
Бүрдүүлэлтийн хувь		99,75	99,87	99,89	99,79
Мэдүүлгийн зөрчлөөр хариуцлага тооцуулсан албан тушаалтны тоо, бүгд		58	73	66	49
Үүнээс	-сануулах арга хэмжээ	24	55	53	26
	-анхааруулах арга хэмжээ	-	-	11	18
	-цалинг бууруулсан	30	15	1	1
	-зэрэг дэвийг бууруулсан	-	2	-	-
	-ажлаас халсан	4	1	1	4

2.1.13 Мэдүүлгийн шинэчилсэн бүрдүүлэлтээр мэдүүлгээ гаргаж өгөөгүй болон хугацаа хожимдуулж бүртгүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцуулахаар 27 байгууллагын удирдах албан тушаалтанд албан бичиг

хүргүүлэх ажлыг зохион байгуулсан ба 22 байгууллагаас ажлаас халсан-4, цалинг бууруулсан-1, сануулсан-26, анхааруулсан-18, хариуцлага тооцох боломжгүй-12 албан тушаалтан, нийт 61 албан тушаалтанд хариуцлага тооцсон талаар хариу ирүүлсэн байна.

2.1.14 ХОМ-ийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа бүрдүүлэлтийн явц байдлын мэдээг 1 дүгээр сарын 20-ноос эхлэн 7 хоног бүр авч, мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангасан.

2.1.15 Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлын урьдчилсан явц байдлын болон нэгдсэн дүнгийн талаарх мэдээллийг телевиз, радио, сонин, сэтгүүл, цахим хуудсууд, газрын цахим хуудас, ЭБАТ булангаар тогтмол мэдээлж, газрын удирдлагыг тухай бүр мэдээллээр хангаж ажилласан.

2.1.16 Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, ажлаараа тэргүүлсэн Нийслэлийн ЗДТГ-ын ЭБАТ-ыг Нийслэлийн ЗДТГ-тай хамтран шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан.

2.1.17 Бүх аймаг, нийслэлийн Засаг дарга, ИТХ-ын дарга нарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргаж ирүүлж байх талаар зөвлөмжийг хүргүүлсэн.

2.1.18 ХОМ-ийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд цалингийн нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлүүлэх тухай албан бичгийг төрийн болон нутгийн захиргааны 10 байгууллагын удирдах албан тушаалтанд хүргүүлж, 8 эрх бүхий албан тушаалтанд нэмэгдэл олгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн.

2.1.19 Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтны нэрсийн жагсаалтанд оруулах шаардлагагүй албан тушаалтны талаар үндэслэл бүхий санал авах албан бичгийг ЗХЖШ, ХХЕГ, ЦЕГ, ШШГЕГ, ОБЕГ, ТӨХ-ын удирдах албан тушаалтанд хүргүүлж хариуг авч шийдвэрлүүлсэн.

2.1.20 Дэлхийн банкны ажилтнуудтай хийсэн видео ярилцлаганд 2 удаа оролцож, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд орсон өөрчлөлтийн талаар тэдний сонирхсон асуултанд хариулж, шинэ хууль, түүнтэй холбоотой хийгдэж байгаа ажлын талаар мэдээлэл өгч, харилцан мэдээлэл солилцсон.

2.1.21 Төрийн байгууллага, албан тушаалтнуудад хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах тухай болон хуулийн үйлчлэлд зарим албан тушаалтнуудыг хамруулах эсэх талаар зөвлөмж, чиглэлийг өгч ажилласан.

2.1.22 Бүрдүүлэлтийн ажлын тайлан, мэдээ, бүртгэлийн 6 төрлийн маягт, хөтлөх зааврыг боловсруулж, газрын даргын тушаалаар батлуулан хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

2.1.23 Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах 125 байгууллагад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын 5 дугаар тогтоолоор батлагдсан журам, маягтууд, газрын даргын тушаалаар батлагдсан бүрдүүлэлтийн ажлын тайлан, мэдээ бүртгэлийн маягтуудыг хүргүүлэн газрын цахим хуудсанд байршуулсан.

2.1.24 Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам, мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмыг газрын даргын тушаалаар батлуулан эдгээрийг төрийн болон нутгийн захиргааны 112 байгууллага, УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж газрын цахим хуудсанд байршуулсан.

2.1.25 Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар тус газарт баримт, материал ирүүлэхдээ баримтыг бүрэн бүрдүүлж ирүүлж байх талаар албан бичиг боловсруулж, төрийн болон нутгийн захиргааны төв 113 байгууллагын удирдлагад албан бичиг хүргүүлсэн.

2.1.26 Орон нутгийн сонгуулийн ажилтай холбогдуулан сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг бөглөх загвар жишээг боловсруулж, газрын цахим хуудсанд байрлуулсан ба аймаг, сум, дүүргийн сонгуулийн хорооны ажилтнууд болон сонгуульд нэр дэвшигчдэд загвар жишээг хүргүүлж, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж ажиллах талаар СЕХ-нд албан бичиг хүргүүлсэн.

2.1.27 Улсын Их Хурлын сонгууль, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль, орон нутгийн сонгуультай холбогдуулан сонгуульд нэр дэвшигчийн мэдүүлгийг хэрхэн бүртгэн авч, хяналт тавих талаар Сонгуулийн ерөнхий хорооны удирдах албан тушаалтнууд болон эрх бүхий албан тушаалтантай байнгын хамтын ажиллагаатай ажиллаж сонгогдогчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан.

2.2 Бүрдүүлэлтийн хяналт шалгалтын ажлын талаар

2.2.1 Газрын даргын баталсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах удирдамж”-ийн дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, холбогдох журмын хэрэгжилтийг шалгах ажлын удирдамжийг боловсруулж, шалгах байгууллагын жагсаалтыг гарган 2012 оны 10 дугаар сарын 15-наас эхлэн Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Газрын тосны газар, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Төрийн өмчийн хороо, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар зэрэг 7 байгууллагад шалгалт хийсэн.

2.2.2 Энэхүү шалгалтаар давхардсан тоогоор 1199 албан тушаалтны мэдүүлгийг хянаж, мэдүүлгийн бүрдүүлэлтээр нийт 809 зөрчил илрүүлсэн. Шалгалтанд хамрагдсан 7 байгууллагаас Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, газрын тосны газар, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газар, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын ЭБАТ-ны үйл ажиллагааг хангалттай, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Төрийн өмчийн хорооны ЭБАТ-ны үйл ажиллагааг дунд түвшинд байна гэж дүгнэсэн.

Бүрдүүлэлтийн хяналт шалгалтын ажлын үр дүнг нэгтгэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, мэдүүлэг гаргагч болон ЭБАТ-дыг мэдээллээр хангах, хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх талаар тодорхой ажлуудыг хийх талаар дээрх байгууллагын дарга нарт албан бичиг хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

2.2.3 Бүрдүүлэлтийн хяналтаар илэрсэн 78 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн зөрчлийг нарийвчлан шалгахгаар танилцуулгыг мэдүүлгийн хуулбарын хамт тус хэлтсийн хяналт шалгалтын албанд шилжүүлсэн.

2.2.4 Мэдүүлэг гаргагчдаас хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлттэй холбоотой ирүүлсэн 2 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн холбогдох албан тушаалтанд хариу өгсөн.

2.3 Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар


2.3.1 Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны судалгааг 2 удаа хийсэн.

Эхний судалгаагаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад нийт 1472 ЭБАТ ажиллаж байна. Үүнээс төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагын ЭБАТ 121, төрийн байгууллагуудын салбар, нэгжийн ЭБАТ 479, сумдын ИТХ-ын ЭБАТ 327, сумдын ЗДТГ-ын ЭБАТ 345, аймгийн ЗДТГ-ын агентлагуудын ЭБАТ 200 байна. Дээрх 1472 ЭБАТ-ны 1071 нь ХОМ-ийг бүртгэх, хадгалах ажлыг гүйцэтгэдэг бол 401 нь ХОМ-ийг бүртгэх ажлыг гүйцэтгэдэг бөгөөд өөрийн байгууллага дээр ХОМ-ийг хадгалдаггүй байна.

Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт орсон, Засгийн газар шинээр байгуулагдсантай холбогдуулан дээрх судалгааг 2012 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар дахин гаргахад улсын хэмжээнд нийт 1448 ЭБАТ ажиллаж байна. Үүнээс төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагын ЭБАТ 113, төрийн байгууллагуудын салбар, нэгжийн ЭБАТ 457, сумдын ИТХ-ын ЭБАТ 326, сумдын ЗДТГ-ын ЭБАТ 345, аймгийн ЗДТГ-ын агентлагуудын ЭБАТ 207 байна.

Нийт ЭБАТ-ны 1087 нь ХОМ-ийг бүртгэх, хадгалах ажлыг гүйцэтгэдэг бол 361 нь ХОМ-ийг бүртгэх ажлыг гүйцэтгэдэг бөгөөд өөрийн байгууллага дээр ХОМ-ийг хадгалдаггүй байна.

График-2



2.3.2 Төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагын ЭБАТ нарын албан тушаал, ажилласан жил, цалингийн нэмэгдэл, утас, майл хаягийн судалгааг шинэчлэн гаргасан.

Төрийн болон нутгийн захиргааны 121 байгууллагын хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны 91 нь буюу 75,2 хувь нь цалингийн нэмэгдэл авч, 30 нь буюу 24,8 хувь нь нэмэгдэл авахгүй байна. Цалингийн нэмэгдэл авч байгаа ЭБАТ-ын нэмэгдлийн хамгийн өндөр нь 40 хувь, хамгийн бага нь 5 хувь бөгөөд нэмэгдлийн дундаж хувь 16,1 байна.

ЭБАТ-аар ажилласан хугацааг авч үзвэл, нийт ЭБАТ-ны 56 нь 4-6 жил, 43 нь 2-3 жил, 22 нь 1 хүртэлх жил ажиллаж байна.



2.4 Сургалт, сурталчилгааны ажлын талаар

2.4.1 Сургалт сурталчилгааны ажлын хүрээнд 2012 онд нийт **416** байгууллагын **20435** албан тушаалтанд мэдүүлгийг хэрхэн бөглөх болон хууль тогтоомжийн талаар сургалт хийснээс **18991** нь мэдүүлэг гаргагч, **1444** нь мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан байна.

2.4.2 Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч, ЭБАТ нарт зориулсан гарын авлага, зөвлөмжийг шинэчлэн боловсруулж, хэвлэлтэнд бэлтгэсэн ба төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудад гарын авлага 2500 ш, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан зөвлөмж 1500 ш, ХОМ гаргагчид зориулсан хэвлэмэл хуудас 15000 ширхэгийг тус тус хуваарилан хүргүүлсэн.

2.4.3 Газрын даргын баталсан хуваарийн дагуу телевиз, радио, сонин, сэтгүүл, цахим мэдээллийн хэрэгслийн сэтгүүлч, сурвалжлагч нарт 3 удаа мэдээлэл хийсэн ба хэлтсийн үйл ажиллагаа, мэдүүлгийн бүрдүүлэлтийн явц байдал, нэгдсэн дүн, хөрөнгө, орлогын мэдүүлгийн зөрчил гаргасан албан тушаалтнуудад хүлээлгэсэн хариуцлагын талаар давхардсан тоогоор уулзалтанд оролцсон 50 орчим сэтгүүлч, сурвалжлагч нарт мэдээлэл өгсөн.

2.4.4 Мэдүүлгийн бүрдүүлэлтийн явц байдал, албан тушаалтнуудаас хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргахдаа гаргадаг нийтлэг зөрчил, тэдэнд хүлээлгэх хариуцлагын талаар Ийгл, Оллоо, Эх орон, Монгол, Шууд, За, ТВ5, ТМ, NTV, SBN, 25 дугаар суваг зэрэг 11 телевизийн суваг, Монголын үндэсний радиогийн Хурд агентлагийн Тусгал шууд нэвтрүүлэг, Тайм цахим хуудас, Монголын үнэн, Монголын мэдээ, Өдрийн шуудан, Ардчилал сонинд сонинд ярилцлага өгсөн.

2.4.5 Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн явц, байдлын мэдээг 2 дугаар сарын 9-нөөс эхлэн өдөр бүр газрын цахим хуудас, ЭБАТ буланд мэдээлсэн ба нэгдсэн дүнгийн талаар телевиз, радио, сонин, цахим хуудсанд мэдээлэл өгч, газрын цахим хуудсанд мэдээлсэн.

2.4.6 Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авч дуусах хугацааг сануулсан болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн ач холбогдлыг иргэд, олон нийтэд сурталчилсан телевизийн сурталчилгааг UBS, TV8, 25 дугаар суваг телевизээр цацаж олон нийтэд хүргэсэн. Мөн хуулийн хугацааг сануулсан баннерыг байршуулсан.

2.4.7 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг

хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журмын хэрэгжилтийн хүрээнд хийгдэж байгаа ажлууд болон ХОМ-ийн хяналт шалгалт, дүн шинжилгээний ажлын явц, үр дүнгийн талаар МҮОНТ, UB, NTV, eagle телевиз, өдрийн сонин, news.mn цахим хуудсын сэтгүүлч, сурвалжлагч нарт мэдээлэл хийсэн.

2.4.8 “Авлигын эсрэг хамтдаа” уриан дор газрын үйл ажиллагааг сурталчлах ажиллагаанд 2 удаа хэлтсийн хамт олныг бүрэн хамруулж оролцуулсан бөгөөд энэ ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

- тус хэлтсээс хийх ажлын талаар хэвлэлийн товч мэдээлэл бэлтгэж цахим хуудас болон хэвлэл мэдээллийнхэнд өгсөн,

- газраас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох төрийн байгууллагын албан тушаалтнуудад албан бичиг хүргэж, тэднийг дээрх үйл ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулсан,

- хэлтсийн үйл ажиллагааны талаар 2 төрлийн самбарыг хийлгэж олон нийтэд сурталчилсан,

- мэдүүлэг, мэдэгдлийн маягтыг олшруулж, хүсэлт гаргасан хүмүүст тараасан,

- ЭБАТ, мэдүүлэг гаргагчдад хэлтсийн үйл ажиллагааг сурталчлах, мэдүүлэг, мэдэгдлийн маягтыг хэрхэн бөглөх талаар зөвлөгөө өгөх ажлыг хийсэн.

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журмын хэрэгжилтийн хүрээнд хийгдэж байгаа ажлууд болон “Авлигын эсрэг хамтдаа” үйл ажиллагааны зорилго, ач холбогдлын талаар МҮОНТ, UB, NTV, eagle телевиз, өдрийн сонин, news.mn цахим хуудсын сэтгүүлч, сурвалжлагч нарт ярилцлага өгсөн.

2.4.9 Монголын Залуучуудын Холбооноос зохион байгуулсан Авлигын эсрэг арга хэмжээнд хэлтсээс 3 ажилтан оролцож, хэлтсийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан.

2.4.10 Мэдүүлгийн маягтыг бөглөх талаарх сургалтын чанарыг сайжруулах зориолгоор сургалтын явцад гарсан асуултыг хэлтсийн ажилтнуудаас авч нэгтгэсэн.

2.4.11 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэчлэн бүртгэсэн тухай хэвлэлийн мэдээ бэлтгэж, газрын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сурвалжлагч нарт мэдээлэл өгсөн. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн дүнгийн талаар Эх орон, С1 телевиз, Өдрийн сонин сурвалжлагчид ярилцлага өгсөн. Мэдүүлгийн бүрдүүлэлт, төрийн өмчит компанид ажиллаж байгаа гадаадын иргэдээс мэдүүлэг авах талаар Эх орон телевизийн сурвалжлагчид ярилцлага өгсөн.

2.4.12 Газраас 10 сарын 8-нд хэвлэл, мэдээллийнхэнд зориулж зохион байгуулах “Авлигын эсрэг хамтдаа” өдөрлөгт зориулж мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны хийсэн ажлын талаар танилцуулга, мэдээллийг бэлтгэсэн.

2.4.13 Вьетнам улсын Ханой хотод болсон Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын 11 дэх удаагийн семинарт оролцож, “Авлигатай тэмцэхэд хөрөнгө, орлогын мэдүүлгийн үр нөлөө” сэдэвт хэсэгт Монгол улсын ХОМ-ийн тогтолцоо, ХОМ-ийг шалгах үйл ажиллагаа, үр дүн” сэдвээр илтгэл тавьсан.

ГУРАВ. МЭДҮҮЛГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

3.1. Тайлангийн хугацаанд хэлтсийн ажилтнууд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан

сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг татан авч нарийвчлан шалгах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэлээ.

3.2. Хяналт шалгалтын ажлын хүрээнд хэлтсийн төлөвлөгөөт хяналт шалгалтын дагуу хууль, хяналтын байгууллага болох Цагдаагийн ерөнхий газар, Шүүх, Прокурорын байгууллага, Газрын даргын 2012 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу, мөн иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, мэдээлэл, бусад хэлтэс албадаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт **238** албан тушаалтны мэдүүлгийг нарийвчлан шалгаснаас **192** албан тушаалтны мэдүүлгийг хянан шалгах ажиллагааг дуусгаж, **46** албан тушаалтны мэдүүлгийг шалгаж байна.

3.3. Газрын даргын баталсан удирдамжийн дагуу Барилга барих зөвшөөрөл, барилгын техникийн нөхцөл олгодог, хяналт тавьдаг байгууллагууд болох нийт **6** байгууллагын холбогдох албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах аас 2 байгууллагын **24** албан тушаалтны мэдүүлгийг хянан шалгасан одоо 4 байгууллагын 50 орчим албан тушаалтнуудын мэдүүлгийг хянан шалгах ажиллагаа үргэлжилж байна.

3.4 Өнөөдрийн байдлаар өргөдөл гомдол болон мэдүүлгийн хяналт шалгалтын зөрчлөөр **41** албан тушаалтанд сануулах, **45** албан тушаалтанд албан тушаалын цалинг бууруулах, **4** албан тушаалтны албан тушаалыг бууруулах, **12** албан тушаалтныг ажлаас чөлөөлж, бусад арга хэмжээ **2**, бүгд **104** албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулан хариуцлага тооцуулсан байна.

Хяналт шалгалтаар хариуцлага тооцуулсан албан тушаалтны судалгааг 2011, 2012 оны харьцуулсан хүснэгтээр /Хүснэгт-2/ үзүүлбэл:

Хүснэгт-3

Д/д	Хууль тогтоомжид зааснаар хариуцлага тооцуулсан арга хэмжээний төрөл	Харьцуулалт	
		2011 он	2012 он
1.	Сануулсан	55	41
2.	Цалинг бууруулсан	13	45
3.	Албан тушаал бууруулсан	2	4
4.	Ажлаас халсан буюу чөлөөлсөн	1	12
5.	Бусад арга хэмжээ	2	2
	Нийт	73	104

Жич: Өнөөдрийн байдлаар мэдүүлгээ зөрчилтэй мэдүүлсэн нийт 13 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд албан бичиг хүргүүлж, биелэлтэнд нь хяналт тавьж ажиллаж байна.

3.5 Хяналт шалгалтын үйл ажиллагааны чиглэл, үр дүн цаашид авах арга хэмжээний талаар хэвлэлийн мэдээ бэлтгэж, Газрын удирдлагаас өгсөн үүргийн дагуу хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллагад 3 удаа хэвлэлийн бага хурал зарлаж мэдээлэл хүргэсэн байна.

ДӨРӨВ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

4.1. Өргөдөл, гомдол, мэдээллийг хуульд заасан шаардлагад нийцүүлэн шалгаж хууль тогтоомжийн хүрээнд явуулах зорилгоор хэлтсийн өргөдөл, гомдлын нэгдсэн бүртгэл, хариуцлага тооцуулсан албан тушаалтны бүртгэлийг тогтмол хөтлөн ажилтан бүрийн өдөр тутмын үйл ажиллагаа, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт болон тэдгээрийн явц байдал, үр дүнд хяналт тавьж ажилласан.

4.2. Тус хэлтэст ирсэн өргөдөл, гомдол, мэдээллийг ажилтнуудын ажлын ачааллыг харгалзан хуваарилж, өргөдөл, гомдлын материалтай нэг бүрчлэн танилцан танилцуулга бичсэн ажилтнуудын санал, дүгнэлт үндэслэлтэй эсэх, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шалгаж байгаа эсэх зэрэгт хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажилласан.


4.3. 2012 онд нийт **168** иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авснаас **161** өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэсэн одоо **7** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна. Хянан шийдвэрлэсэн **161** өргөдөл, гомдлоос холбогдох арга хэмжээ авахуулахаар **78**, харъяаллын дагуу холбогдох Төрийн байгууллагад шилжүүлсэн **9**, гомдол гаргагч гомдлоосоо татгалзсан **8**, Шалгалтын явцад гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар Мөрдөн шалгах хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтэс, Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн **15**, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст шилжүүлсэн **2**, бусад **49** гомдлыг тус тус шийдвэрлэсэн байна.

4.4. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын агуулгыг зөрчлийн хэлбэрээр нь авч үзвэл иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээтэй холбоотой хүнд суртал чирэгдэл гаргадаг, албан тушаалтны ёс зүйн зөрчил гаргасан талаар **21** буюу 12 хувийг албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн, урвуулан ашигласан байж болзошгүй талаар **28** буюу 17 хувийг, хууль тогтоомж зөрчсөн, хууль бус үйлдэл гаргасан талаар **74** буюу 44 хувийг, албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгуулахаар хандсан **45** буюу 27 хувийг тус тус эзэлж байна.

График-4



4.5. Хянан шийдвэрлэсэн нийт 160 гомдол, мэдээллээс **126** буюу 78.75 хувийг хуулийн хугацаа болох 1 сарын хугацаанд, **34** буюу 21.25 хувийг сунгасан буюу 2 сарын хугацаанд шалгаж шийдвэрлэсэн байна.



4.6 Хяналт шалгалтын ажлын явцад илэрсэн зөрчил дутагдлыг засуулах, төрийн байгууллагын авлига, хүнд суртлыг арилгах, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, хөнгөн шуурхай болгох, төрийн албан хаагч нарын ёс зүй, харьцааны соёлыг дээшлүүлэх, үйл ажиллагааны доголдол, дутагдлыг засах шаардлагыг төрийн байгууллага, орон, нутгийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран албан бичиг, зөвлөмж хүргүүлж шийдвэрлүүлсэн байна.

ТАВ. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛГИЙГ ХЯНАСАН АЖЛЫН ТАЛААР

5.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тус хэлтсээс хянаж холбогдох байгууллагад дүгнэлт гаргах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

5.2 2012 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн **3232** этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас **3106** этгээдийн мэдүүлгийг хянаж холбогдох хариуг хүргүүлсэн одоо **126** этгээдийн мэдүүлэг хянагдаж байна.

5.3 Хянаж хариу хүргүүлсэн **3106** этгээдийн урьдчилсан мэдүүлгээс Ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоосон, анхааруулсан нийт **274**, хянах боломжгүй үндэслэлээр **190** мэдүүлгийг буцаан хүргүүлсэн байна.

5.4 2012 онд Засгийн газар шинэчлэн байгуулагдсан, Улсын Их Хурлын сонгууль, Орон нутгийн сонгууль болсонтой холбогдуулан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянаж дүгнэлт гаргах үйл ажиллагаа эрчимтэй явагдаж хэлтсийн хэмжээнд 7 хоногт **120-140** албан тушаалтны мэдүүлгийг хянаж хариу хүргүүлсэн бөгөөд 1 ажилтан дунджаар **360** орчим албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг хянаж танилцуулга бичиж холбогдох байгууллага, албан тушаалтанд албан бичиг, зөвлөмж боловсруулж хүргүүлсэн байна.

ооОоо